

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Суралцагчийн төлөвшил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Лхасүрэн Отгонбаатар

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1.1. Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын асуудлаар баримтлах төрийн бодлого хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах /албан тушаалын зорилго, зорилтод суурилсан тжах-ийн гүйцэтгэлийн зорилт/							
1	Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран батлуулж, хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	-	50% /хувь/	Суралцагчийн хөгжлийн газар нь 2025 онд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4 чиглэлээр 13 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Батлагдсан төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Боловсролын газар руу Хүүхдийн тусламжийн 108 утасны танилцуулга мэдээллийг суралцагчдад хүргэх тухай албан бичгийг хүргүүлж, нийт ерөнхий боловсролын 165 сургуулийн 40837 суралцагч, 219 багш ажилтан хамрагдсан байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50%
1.1.2. Хүүхдийн төлөвшил хамгааллын чиглэлээрх үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх							

2	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, эцэг эх асран хамгаалагчдад архи, тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь	-	50%	Боловсролын сайдын 2024 оны А/140 дүгээр тушаалын хэрэгжилт Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн “Боловсролын сургалтын байгууллагын орчинд электрон тамхи хэрэглэхийг хориглох тухай” А/140 дүгээр тушаал батлагдсан. Тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсүүдэд чиглэл хүргүүлж, 7 хоног бүр тогтмол зохион байгуулагддаг шуурхай хурлаар танилцуулга хийж, 84 удирдах мэдээллийг хүргэсэн. Тушаалаар боловсролын сургалтын байгууллагын орчинд /сургуулийн орчинд/ электрон тамхи хэрэглэхийг хориглож, авч хэрэгжүүлэх арга хэмжээг өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын эрхлэгч, захирал, ректор нарт даалгасан. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагууд сургуулийн дүрэм, дотоод журамдаа өөрчлөлт оруулж, дор бүрдээ өөрийн онцлогт тохируулан журмын хэрэгжилтийг хангаж байна. Ерөнхий боловсролын 624 сургууль өөрсдийн цахим хуудастаа 12 төрлийн постер, 25 төрлийн рийл болон энэхүү тушаалын талаарх мэдээллийг байршуулсан. Урлаг, спортын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50%
---	---	-------------------	---	-----	---	---	---------------------

					сургуулиуд манлайлал үзүүлж “Тамхи татдаггүй тамирчин” аяныг өрнүүлсэн. Мөн Боловсролын ерөнхий газрын пейж хуудаст цуврал постер мэдээллийг бэлтгэж олон нийтэд хүргэсэн бөгөөд 596 лайк, 1024 share, 51,451 хүнд хүрсэн байна.		
3	Хүүхдийг зам тээврийн осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	-	-	1	Хүүхэд зорчиж байна НҮТББ нь 2022 оноос эхлэн “10 хүртэлх насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх аргачлал” сургалтыг багш, эцэг эх, асран хамгаалагч нарын мэдлэгийг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх, хүүхэд хамгааллын боловсролтой болгох зорилгоор 3 жилийн хугацаанд танхим, цахим хослуулж зохион байгуулж байна. 2022 оноос 2025 оны хооронд 570 удаагийн сургалтаар 50,000 орчим эцэг эх, асран хамгаалагч, багш нарыг сургалтад үнэ төлбөргүй хамруулсан байна. 2024 оноос эхлэн сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд одоогоор 17 багш төгсөж, 20 гаруй багш нар бэлтгэгдэж байна. 2025 онд 170 цэцэрлэгийн 12,000 орчим эцэг эх, асран хамгаалагч нарт сургагч багш нар танхимаар сургалтыг зохион байгуулсан. Цаашид зөвхөн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх аргачлалаас гадна ахуйн осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх аргачлалыг сургалтын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50%

					агуулгад нэмэлтээр оруулахаар төлөвлөж байна. Жил бүр 500 гаруй хүүхдүүд зам тээврийн осол, өндрөөс унах, гал, үер усны аюулд өртөх зэрэг ахуйн ослоор амь насаа алддаг байна. Сургалтыг багш, эцэг эх, асран хамгаалагч нарт танхимын хэлбэрээр зохион байгуулж байгаа хэлбэрийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нарын оролцоотой олон улсын сургалтын туршлагыг нэвтрүүлсэн хэлбэрээр зохион байгуулахаар судалж байна.		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
4	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хэрэгжилтийн хувь.	-	50%	Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн Б/234 дүгээр тушаалаар Суралцагчийн төлөвшил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдож, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50%
5	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь	Хэрэгжилтийн хувь	-	50%	ТАЗ-ийн даргын 02 дугаар тушаалын дагуу 12 хоног,	1-р сар, 2-р сар, 3-р сар,	Өөрийн

	гүйцэтгэх				Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд 5 хоног, Ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах комиссоор 12 хоног ажиллах үүрэг авч гүйцэтгэсэн. Албан бичиг болон цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврыг өгсөн хугацаанд гүйцэтгэж ажилласан.	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 50%
6	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	50%	Хагас жилийн байдлаар иргэд, албан хаагчдаас ирсэн албан бичиг- 3, өргөдөл 1 хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Мөн иргэд, байгууллагын албан хаагчдаас ирсэн өргөдөл, албан бичгийн дагуу нийт 49 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд хуулийг хэрэгжүүлэн зөрчилгүй ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь

	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Монгол бичгийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, сургалтад хамрагдах	Хэрэгжилтийн хувь.	0	50	Ш.Чоймаа багшийн монгол бичгийн цуврал 3 хичээлийг үзэж судалсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50%
2	Спортын чадвараа сайжруулах.	1	Багийн бэлтгэлд хамрагдаж байгаа.	Ажлын бус цагаар тогтмол бэлтгэл сургуулилт хийх.	Футзалын дээд лигийн Хан-Уул клубтэй 1 жилийн гэрээ хийж бэлтгэл сургуулилтад хамрагдан дээд лигийн 5 тоглолтод оролцоод байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн төлөвшил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Лхасүрэн Отгонбаатар /...../

Огноо: